



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.3, 27¹.6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”, “Нийслэл хотын албан татварын тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 01, 02 дугаар албан даалгавар болон Татварын ерөнхий газраас 2017 онд дэвшүүлсэн “Татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангах” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Татвар төлөгчийн тооллого хийх ажлын нэгдсэн удирдамж”-ийг хавсралтаар баталсугай.

2. Удирдамжид заасан ажлыг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт, тооллогын ажлыг мэргэжил арга зүйн удирлагаар ханган зохион байгуулан тайлагнаж ажиллахыг Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/-т, Татварын орлогын газар /Д.Цогтжаргал/-т тус тус даалгасугай.

3. Удирдамжид тусгагдсан ажлыг хэрэгжүүлэн ажиллахад програм хангамжийн хэвийн байдал, шаардлагатай статистик, судалгаа, мэдээг гаргахад харьяа нэгжид дэмжлэг үзүүлэхийг Мэдээлэл статистик, технологийн төв /Г.Батсайхан/-д, холбогдох санхүүжилтээр санхүүжүүлж ажиллахыг Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс /Л.Бямбадорж/-т тус тус үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Б.Заяабал/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАНДАНБАТ

ТЕГ-ын даргын 2017 оны 11 сарын 30
өдрийн 11 дугаар тушаалын
хавсралт



ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ТООЛЛОГО ХИЙХ АЖЛЫН НЭГДСЭН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1. Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 01, 02 дугаар албан даалгавар болон Татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны зорилт, "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль", "Нийслэл хотын албан татварын тухай хууль"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мөн татвар төлөгчөөр бүртгэгдвэл зохих хуулийн этгээд, хувь хүн, татвар ногдох зүйлийн бүртгэлийн мэдээллийг сайжруулах, татвар төлөгчийн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгох, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн байршил, татварт хамрагдалт, хуулийн хэрэгжилтийг тодорхойлох, цаашид хуулийн этгээдийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлийн ажлыг нягт уялдуулах, татварын бааз суурийг нэмэгдүүлэхэд энэхүү тооллогын ажлын зорилго оршино.

Хоёр. Тооллогын ажлын хамрах хүрээ

2.1. Аймаг, нийслэл, дүүргийн татварын алба нутаг дэвсгэрийн зарчимаар үйл ажиллагаа эрхлэж буй татварын албанд бүртгэлтэй болон бүртгэлгүй татвар ногдох үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, түрээслэгч, хувь хүн, хуулийн этгээд, төсөвт болон төрийн бус байгууллага, салбар, төлөөлөгчийн газар, сан, сууц өмчлөгчдийн холбоо, төлөөний газар, бизнесийн үйл ажиллагаа явуулж төлбөрийн баримт олгох үүрэг бүхий цэгийг татвар төлөгчийн тооллогод хамруулж байршил харуулах зураглалыг сум, баг, хороо, байрлан буй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа үл хөдлөх эд хөрөнгө болон ажлын байр бүрээр гаргах;

2.2. Тооллогын явцад Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17, Нийслэл хотын албан татварын хуулийн хэрэгжилтүүдийг шалган, шаардлагатай бол холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллана.

Гурав. Ажлын хэсэг, багын бүрэлдэхүүн

3.1. Тооллогыг аймаг, нийслэл татварын газар, хэлтсийн даргын тушаалаар баталсан ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, албан хаагчдын бүрэлдэхүүнтэй хийнэ.

3.2. Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нутаг дэвсгэрийн зарчимаар сум, баг, хороонд ажиллах тооллогын ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нэгжид ажиллах баг болон ажиллах хуваарийг тушаалаар батлан, өдөр тутмын удирдлагаар хангаж, ажлын гүйцэтгэлд биечлэн хяналт тавина.

3.3. Нийслэлийн татварын газрын даргын тушаалаар нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд, аймгийн татварын хэлтсийн даргын тушаалаар аймаг, сумын хэмжээнд хяналтын тооллого явуулах ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Тооллогын хугацаа

4.1. Аймаг, дүүргийн тооллогыг харьяа нутаг дэвсгэртээ 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд улсын хэмжээнд нэгэн зэрэг хийнэ.

4.2. Тооллогын явцад цуглуулсан татвар төлөгчийн мэдээлэл, Татвар төлөгчийн үйл ажиллагааны байрлал тодорхойлох зургыг бүртгэлийн програмд оруулах. (Бүртгэх програм хангамжийн хугацаатай уялдуулан ТЕГ-аас чиглэл хүргүүлнэ.)

4.3. Татварын албад хяналтын тооллогыг 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд харьяа нутаг дэвсгэрт зохион байгуулна.

Тав. Удирдлага зохион байгуулалт

5.1. Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газар нь татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой ажлыг, Татварын орлогын газар нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хийгдэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

5.2. Нийслэлийн татварын газар нь нийслэлийн хэмжээнд татвар төлөгчийг тооллогын ажиллагааг зохион байгуулан бүрэн хамруулсан эсэхэд хяналт тавьж, ажлын зохион байгуулалтыг удирдлагаар ханган, тооллогын ажлын нэгдсэн мэдээ, судалгаа, нэгтгэл, тайланг Татварын ерөнхий газарт ирүүлэх;

5.3. Тооллогын бэлтгэл ажил болон удирдлага, зохион байгуулалтаар хангах, тооллогыг үр дүнтэй зохион байгуулах, дүн мэдээг хянаж, нэгтгэх ажлыг харьяа татварын албаны даргын батласан ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга хариуцан гүйцэтгэх;

5.4. Харьяа татварын алба энэ ажилд Орон нутгийн Засаг дарга болон төрийн захиргааны байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг, туслалцаа авах, шаардлагатай тохиолдолд хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллах;

5.5. Хяналтын тооллогыг цаг хугацаа, нутаг дэвсгэрийн байршлаас хамааран Аймгийн татварын алба бүсчилсэн, Нийслэлийн татварын газар түүвэрчилсэн байдлаар харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

Зургаа. Тооллогын бэлтгэл ажил

6.1. Харьяа татварын алба өөрийн нутаг дэвсгэрийн газар зүйн байрлал, татвар ногдох зүйл, объектыг тодорхойлон, сум, баг, хороо бүрт тооллогын ажлын хэсэг, багын хүн хүчний нөөцийг зохистой хуваарилахад анхаарч ажиллах;

6.2. Нийслэлийн хэмжээнд тооллогын ажил зохион байгуулахдаа тухайн татварын албаны сүлжээний инженер "tax inspector" гар утасны аппликейшныг тооллого хийх багын албан хаагчийн гар утсанд суулгах ажлыг зохион байгуулах;

6.3. Тооллогод татвар төлөгчдийг бүрэн хамруулахад анхаарч зохион байгуулалтын бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Долоо. Тооллого явуулах хэлбэр

7.1. Тооллогыг тухайн татварын албаны харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа байршлаар нь тухайн татварын албанд бүртгэлтэй эсэхээс үл хамааран татвар төлөгч бүрээр үйл ажиллагаа эрхлэж буй газар дээр нь тоолох хэлбэрээр явуулна.

7.2. Тооллогод Татварын албаны "tax inspector" гар утасны аппликейшныг ашиглана.

Найм . Тооллогоор хийж хэрэгжүүлэх ажил

8.1.Татварын алба нь өөрийн нутаг дэвсгэрт /харьяалал харгалзахгүйгээр/ үйл ажиллагаа явуулж байгаа, татвар ногдох үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигч, ашиглагч, түрээслэгч хувь хүн, хуулийн этгээд, салбар төлөөлөгчийн газар, сан, сууц өмчлөгчдийн холбоо, бизнесийн үйл ажиллагаа явуулж төлбөрийн баримт олгох үүрэг бүхий цэг бүрийг тоолно;

8.2.Тооллогын явцад татварын албанд бүртгүүлээгүй болон Улсын бүртгэлийн гэрчилгээнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтийг татварын албанд бүртгүүлээгүй татвар төлөгчийн мэдээллийг бүртгэх;

8.3.Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа боловч өөр татварын албанд бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй татвар төлөгчийг харьяа татварын албанд мэдээлэх, мэдээлэл харилцан солилцох, хөндлөнгийн мэдээллийн санд бүртгэх, харьяа алба шинээр бүртгэн авах ажлыг зохион байгуулж, орон нутагт байрлах татвар төлөгчийн мэдээллийг Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газарт, Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах татвар төлөгчийн мэдээллийг Нийслэлийн татварын газарт хүргүүлэх;

8.4. Хувь хүн, хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг тоолж бүртгэнэ;

8.5.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа үл хөдлөх эд хөрөнгө болон ажлын байрыг түрээсээр эзэмшиж байгаа нөхцөлд түрээслүүлэгч, түрээслэгч, давхар түрээслэгч хувь хүн, хуулийн этгээдийг тус тусад нь тоолж бүртгэх;

8.6. Тооллогод хамрагдсан үл хөдлөх хөрөнгийн фото зургийг авах, нэгтгэл хүснэгтэнд хавсаргах, тухайн үл хөдлөх хөрөнгийн хаяг, байршлыг бүртгэх;

8.7. Төлбөрийн баримт олгох, нэгдсэн системд илгээх үүрэг бүхий татвар төлөгч нэг бүрийг тоолж, тооллогын явцад дараах хяналтыг хэрэгжүүлэх;

8.7.1. Татвар төлөгч борлуулалтыг төлбөрийн баримтад зөв бүртгэж байгаа эсэх, бүртгэлийн мэдээллийг нэгдсэн системд дамжуулах тусгай зориулалт бүхий кассын машин, түүний салшгүй хэсэг болсон пос терминал буюу түүнтэй адилтгах програм хангамж бүхий тоног төхөөрөмж (бүртгэлийн машин) суурилуулсан эсэхэд хяналт тавих;

8.7.2. Тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан төлбөрийн баримтыг олгож буй эсэхэд хяналт тавих;

8.7.3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагаас зохих зөвшөөрлийг авсан эсэх, хугацаа сунгасан эсэх талаар шалган, үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн талаар бүртгэл хөтлөн, ногдох татварыг тайлангийн хугацаанд төлөх талаар шаардлага өгөх;

8.7.4. Бараа, ажил, үйлчилгээнд төлбөрийн баримт олгохгүй байгаа бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдэд албан шаардлага тавьж холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлага бичих;

8.8. Татвар төлөгчийн тоолохдоо хувь хүн бол "Татвар төлөгч хувь хүний тооллогод хамруулсан хуудас" (Хавсралт 4), аж ахуйн нэгж байгууллага бол "Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын тооллогод хамруулсан хуудас" (Хавсралт 5), мөн төвлөрсөн зах, худалдаа, үйлчилгээний төвд үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага бол "Төвлөрсөн зах, худалдаа, үйлчилгээний төвд байрлах татвар төлөгчийн тооллогод хамруулсан хуудас" (Хавсралт 6)-ыг үнэн, зөв, нягт, нямбай, ойлгомжтой, цэвэрхэн бөглөн албажуулан мэдээлэл нэгтгэх татварын улсын (ахлах) байцаагчид хүлээлгэн өгөх;

8.9.Татвар төлөгчийн тооллогод хамруулсан хуудсыг хүлээн авсан татварын улсын (ахлах) байцаагч тооллогод хамруулсан төрөл бүрээр (Хавсралт 1), (Хавсралт 2), (Хавсралт 3) хүснэгтийн дагуу мэдээллийг алдаагүй нэгтгэн ажлын үр дүнг гаргаж, тухайн татварын албаны удирдлагад танилцуулах;

8.10. Аймаг, нийслэл, дүүргийн татварын алба Татвар төлөгчтэй харилцах газар, Татварын орлогын газартай нягт холбоотой ажиллаж, асуудлыг тухай бүр тодруулж ажиллах;

8.11. Тооллогод татвар төлөгчийг бүрэн хамруулах, тооллогын хугацаанд тооллогод хамрагдаагүй татвар төлөгчийг нөхөн тооллох, тооллогод оролцоогүй татвар төлөгчийг дуудан ирүүлэх мэдэгдэх хуудас өгөх ажлыг харъяа нутаг дэвсгэрийн зарчмаар татварын албад зохион байгуулж энэ талаарх тайлан мэдээг Татварын ерөнхий газарт ирүүлэх;

8.12. Аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тухайн харъяа нутаг дэвсгэрт хяналтын тооллого хийхдээ түүврийн аргаар сонголт хийж тооллого явуулах;

Ес . Тооллогын дүн, мэдээ, судалгааг нэгтгэх, хүргүүлэх

9.1. Тооллогын дүнг хавсралт маягаар үнэн зөв, тодорхой, бүрэн гүйцэт гарган нэгтгэл хийж, дүн мэдээг нэгтгэх харъяа татварын албаны даргын батласан ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө. Дутуу бүртгэсэн, тоо материал нь ойлгомжгүй, эргэлзээ төрүүлсэн мэдээллийг ажлын хэсэг, баг, албан хаагчид буцааж магадлан шалгуулна.

9.2. Дүүргийн татварын албад тооллогын нэгдсэн дүнг хавсралтын дагуу нэгтгэн үнэн зөв гаргаж, тооллого явуулсан тухай тайлан, хяналтын тооллогын үр дүнгийн хамт 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Татвар төлөгчтэй харилцах хэлтэст хүргүүлнэ.

9.3. Нийслэл, аймгийн татварын алба тооллогын нэгдсэн дүнг хавсралт маягын дагуу үнэн зөв гарган, нэгтгэж, тооллого явуулсан тухай тайлан, хяналтын тооллогын үр дүнгийн хамт 12 дугаар сарын 08-ны дотор Татвар төлөгчтэй харилцах газарт (jamsranjav.d@mta.gov.mn) цахим хаягаар болон цаасан хэлбэрээр баталгаажуулан ирүүлнэ.

9.4.Тооллогын үр дүнгээр татвар төлөгчийн ТБМНС-ын бүртгэлийн мэдээллийг шинэчлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангуулах ажлыг Татвар төлөгчтэй харилцах газар зохион байгуулна.

9.5. Тооллогын дүнг Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газар, Татварын орлогын газар хамтран татварын албаны ирүүлсэн судалгаа, нэгтгэл, тайланд үндэслэн дүгнэлт гарган, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт Татварын ерөнхий газрын даргад танилцуулж холбогдох шийдвэр гаргуулна.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



Зөвхөн татварын
албаны хэрэгцээнд

ТЕГ-ын даргын 2017-оны 11/190 дугаар тушаалаар
баталсан удирдамжийн хавсралт 4



ТАТВАР ТӨЛӨГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГОД ХАМРУУЛСАН ХУУДАС

2017 онсарөдөр

Тооллогод хамруулсан ТА-ны нэр:

Хэсгийг ✓ - тэмдэглэгээ болон тоогоор илэрхийлнэ.

Шинээр бүртгүүлсэн эсэх

| |
|--|
| |
|--|

Дуудан ирүүлэх мэдэгдэл өгсөн эсэх

| |
|--|
| |
|--|

Татвар төлөгчийн харьяа ТА-ны код

| | |
|--|--|
| | |
|--|--|

ТТДугаар

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|

ААН-ийн нэр

.....

Хариуцлагын хэлбэр

.....

Үйл ажиллагаа явуулж буй хаяг, байршил

Аймаг, хот

.....

Сум, дүүрэг

.....

Баг, хороо

.....

Гудамжны нэр, хороолол

.....

Гудамж, байшин

| | | |
|--|--|--|
| | | |
| | | |

Хашаа, хаалга

Байшингийн давхрын тоо

| | |
|--|--|
| | |
|--|--|

Байрлах давхрын тоо

| | |
|--|--|
| | |
|--|--|

Байршлыг тодорхойлох газрын нэр:

.....

Холбогдох Утас 1

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|

Утас 2

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|

Утас 3

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|

Цахим хаяг

.....

Фото зураг авсан эсэх

| |
|--|
| |
|--|

Татварын албанд бүртгүүлэх мэдэгдэл өгсөн эсэх

| |
|--|
| |
|--|

Эрхлэх үйл ажиллагааны Төрөл

| |
|--|
| |
|--|

Чиглэл

.....

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, түрээслүүлэгч бол:

Ашиглалтын зориулалт

| |
|--|
| |
|--|

Үйлдвэрлэл

| |
|--|
| |
|--|

Орон сууц

УБ-ийн гэрчилгээний дугаар

Үйлчилгээ

Нийтийн өмч

Үнэлгээний төрөл

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|

Үнэлгээ /мянган төгрөг/

Бүртгэлийн

Санхүүгийн

Түрээслэгчийн тоо

Даатгалын

Татварын

УХЭХ-ын нийт талбайн хэмжээ (м2)-аар

.....

Түрээсийн орлого (мянган төгрөг): (1 сарын дүн)

| | | | |
|--|--|--|--|
| | | | |
|--|--|--|--|

| | | | |
|--|--|--|--|
| | | | |
|--|--|--|--|

| | | | |
|--|--|--|--|
| | | | |
|--|--|--|--|

.....

Мэдээллийг зөвхөн татварын албаны хэрэгцээнд ашиглана.

... ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ХАРЬЯА НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ТӨВЛӨРСӨН ЗАХ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВД БАЙРЛАХ ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ТООЛЛОГЫН ХҮСНЭГТ


Он, сар, өдөр. 2017 оны сарын -ны өдөр

| Д/д | *Шинээр бүртгүүлсэн эсэх | *Дуудан ирүүлэх мэдэгдэл өгсөн эсэх | Төвлөрсөн зах худалдааны төвийн нэр | ТТ-ын харьяа ТА-ны код | Татвар төлөгч ААНБ бол | | Хаяг, байршил | | | | Хаяглал | | | | | | | |
|-----|--------------------------|-------------------------------------|-------------------------------------|------------------------|------------------------|-------------|--------------------|-----------|------|-----|------------|-------------|------------|-------------------------|----------------|------------------------------|--------|--------|
| | | | | | ТТДуг аар | ААН-ийн нэр | Хариуцлагын хэлбэр | ТТДуг аар | Овог | Нэр | Аймаг, хот | Сум, дүүрэг | Баг, хороо | Байшингийн давхарын тоо | Байрлах давхар | Лангуу, павилоны дугаар, нэр | Утас 1 | Утас 2 |
| 1 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | | | | | | |
| | Нийт дүн | | | | | | | | | | | | | | | | | |

Тайлбар: (*) - гэмдэглэгээг 1-ээр гэмдэглэнэ.

| Цахим хаяг | *Фото зураг авсан эсэх | *ГА-д бүртгүүлэх мэдэгдэл өгсөн эсэх | Эрхлэх үйл ажиллагааны чиглэл | Үл хөдлөх эд хөрөнгө зээмшигч, түрээслүүлэгч | | | | | | Түрээслэгч | | | | | | | | |
|------------|------------------------|--------------------------------------|-------------------------------|--|----------------------------|------------------|-------------------|-------------------|--------------------------------------|-----------------------------------|---------------------------|----------------------------------|--|--|--|--|--|--|
| | | | | Ашиглалтын зориулалт | УБ-ийн гэрчилгээний дугаар | Үнэлгээний төрөл | Үнэлгээ /мян.төг/ | Түрээслэгчийн тоо | ҮХЭХ-ын нийт талбайн хэмжээ (м2)-аар | Түрээсийн орлого (мян.төг) сараар | Татвар төлөгчийн регистер | Татвар төлөгчийн нэр (овог, нэр) | | | | | | |
| | | | | Үйлдвэрлэл | | Татварын | | | | | | | | | | | | |
| | | | | Үйлчилгээ | | Санхүүгийн | | | | | | | | | | | | |
| | | | | Орон сууц | | Даатгалын | | | | | | | | | | | | |
| | | | | Нийтийн өмч | | Бүртгэлийн | | | | | | | | | | | | |

| бол | Түрээслэгчээс түрээслэсэн бол | | | | | | Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем (НӨАТУС) | | | | | |
|-----|---------------------------------------|---------------------------|----------------------------------|---------------------------------------|---------------------------|--|--|--------------------------------|---|--|--|---|
| | Түрээслэж буй талбайн хэмжээ (м2)-аар | Татвар төлөгчийн регистер | Татвар төлөгчийн нэр (овог, нэр) | Түрээслэж буй талбайн хэмжээ (м2)-аар | Түрээсийн төлбөр (сараар) | *ҮХЭХАТ төлөгчөөр бүртгүүлэх мэдэгдэл өгсөн эсэх | *Цахим баримтын систем (e-bagimt.ppt)-аар олгодог эсэх | *Төлбөрийн баримт олгодог эсэх | *Кассын болон пос машин холбогдсон эсэх | *Цахим төлбөрийн баримтын систем (e-bagimt.ppt)-аар олгодог эсэх | *Хуулийн хугацаанд нэгдсэн системд илгээсэн эсэх | Шаардлагын хуудас өгсөн бол түүний дугаарыг бичих |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |



ТЭГ-ын даргын 2017 оны 1190 дугаар тушаалаар багтасан удирдамжийн хавсралт 3